

**МОНГОЛ-ОРОСЫН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН НИЙГЭМЛЭГ
УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ**



**ЗОРЧИГЧИЙН ВАГОНЫ ЦАХИЛГААН ТОНОГЛОЛЫН
СИСТЕМИЙН СЭЛБЭГ ХУДАЛДАН АВАХ
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ**

Тендер
шалгаруулалтын нэр:

**Зорчигчийн вагоны цахилгаан тоноглолын
системийн сэлбэг худалдан авах**

Тендер
шалгаруулалтын
дугаар:

УБТЗ/2024/НТШ/Б/37

Улаанбаатар хот

2024 он

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

| | |
|--|----|
| I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)..... | 1 |
| 1. Тендерийн цар хүрээ..... | 1 |
| 2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг..... | 1 |
| 3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж..... | 1 |
| 4. Сонирхогч этгээд, оролцогч..... | 2 |
| 5. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ..... | 2 |
| 6. Нийлүүлэх барааны гарал үүсэл..... | 2 |
| 7. Тендер шалгаруулалтын баримт бичиг..... | 3 |
| 8. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах..... | 3 |
| 9. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт..... | 3 |
| 10. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл..... | 3 |
| 11. Тендерийн иж бүрдэл..... | 4 |
| 12. Тендерийн жишиг маягтууд..... | 5 |
| 13. Хувилбарт санал..... | 5 |
| 14. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг..... | 5 |
| 15. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг..... | 5 |
| 16. Чадавхын болон туршлагын шаардлага..... | 7 |
| 17. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт..... | 7 |
| 18. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт.... | 8 |
| 19. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт..... | 8 |
| 20. Тендерийн валют..... | 9 |
| 21. Тендер хүчинтэй байх хугацаа..... | 9 |
| 22. Тендерийн баталгаа..... | 9 |
| 23. Тендер баталгаажуулах, илгээх..... | 9 |
| 24. Тендер хүлээн авах эцсийн хугацаа..... | 10 |
| 25. Тендерийн талаар тодруулга авах..... | 10 |
| 26. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх..... | 10 |
| 27. Тендерийг үнэлэх..... | 10 |
| 28. Арифметик алдааг залруулах..... | 10 |
| 29. Оролцогчид давуу эрх олгох..... | 11 |
| 30. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт..... | 11 |
| 31. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох..... | 11 |
| 32. Тендерийг эрэмбэлэх..... | 11 |

| | | |
|-----|---|----|
| 33. | Оролцогчийн чадавхыг дахин магадлах | 11 |
| 34. | Мэдэгдэл хүргүүлэх | 11 |
| 35. | Гүйцэтгэлийн баталгаа..... | 12 |
| 36. | Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах..... | 12 |

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Тендерийн цар хүрээ
 - 1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон бараа, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “бараа” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана.
 - 1.2. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана.
 - 1.3. Барааг бүхэлд нь, эсхүл түүний тодорхой багцын барааг хуулийн 8.1-д зааснаар дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой бол энэ тухай захиалагч өгөгдлийн хүснэгтэд заана. Ийнхүү заасан бол тендер шалгаруулалт, эсхүл түүний багцад зөвхөн Монгол Улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлнэ.
 - 1.4. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгт болон зарлалд заана.
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг
 - 2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж
 - 3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.
4. Худалдан авах ажиллагааны цахим систем
 - 4.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.
5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх
 - 5.1. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.

- 5.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20¹, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.
- 6. Сонирхогч оролцогч этгээд,**
- 6.1. Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.
- 6.2. Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.
- 6.3. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.
- 6.4. Тендер шалгаруулалтад оролцох сонирхлоо илэрхийлэх аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т заасан үйлчилгээний хураамж төлсөн байна.
- 6.5. ТШЗ-ны 6.4-т заасан үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.
- 7. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ**
- 7.1. Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.
- 7.2. Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.
- 7.3. Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.
- 7.4. ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.
- 7.5. Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- 8. Нийлүүлэх барааны гарал үүсэл**
- 8.1. ТШЗ-ны 1.3-т өөрөөр заагаагүй бол гэрээгээр нийлүүлэх бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно.

Б.АГУУЛГА

9. Тендер шалгаруулалтын баримт бичиг

9.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:
I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;
II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;
III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;
IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;
V Бүлэг. Тендерийн жишиг маягт;
VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

9.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

9.3. Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтөд нийцүүлэн тендер бэлтгэнэ.

10. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах

10.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтийг хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар захиалагчид гаргах бол Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүргүүлнэ.

10.2. ТШЗ 10.1-д заасан хүсэлтэд ТШЗ-ны 6.4-т заасан сонирхогч этгээд болохыг нотлох баримтыг хавсаргана.

10.3. Тодруулгын дагуу тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл захиалагч хуулийн 20.6-д заасны дагуу шийдвэрлэнэ.

11. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт

11.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол өгөгдлийн хүснэгтэд заана. Захиалагч уулзалтад ТШЗ-ны 6.6-д заасан сонирхогч этгээд, түүний төлөөллийг оролцуулна.

11.2. ТШЗ-ны 11.1-д заасан уулзалтад оролцоогүй нь аж ахуй эрхлэгчийн тендер шалгаруулалтад оролцох эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл

12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

- 12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа худалдан авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн ТШЗ-ны 12.1-д заасан хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.
- 12.3. Тендер шалгаруулалтын баримт бичгийн хэл болон гадаад хэлээрх хувилбар хоорондоо зөрвөл ТШЗ-ны 12.1-д заасан хэлээр бэлтгэсэн тендер шалгаруулалтын баримт бичгийг баримтална.
- 12.4. Захиалагч ТШЗ-ны 12.1-д зааснаас өөр хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг тендер хянан үзэх, үнэлэхэд ашиглах ба оролцогч өөрөө орчуулсан, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

13. Тендерийн иж бүрдэл

- 13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн бараа нийлүүлэх техникийн болон үнийн санал байна.
- 13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:
 - 13.2.1. ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасны дагуу бэлтгэсэн маягтууд;
 - 13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;
 - 13.2.3. захиалагч зөвшөөрсөн бол ТШЗ-ны 15 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;
 - 13.2.4. оролцогч ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;
 - 13.2.5. санал болгож буй бараа ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;
 - 13.2.6. бараа нийлүүлэлтийн хуваарь;
 - 13.2.7. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 18, ТШЗ 19, ТШЗ 20 дугаар зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;
 - 13.2.8. ТШЗ-ны 21 дүгээр зүйлд заасан барааны үнийн задаргаа;
 - 13.2.9. ТШЗ-ны 21.9-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;
 - 13.2.10. түншлэл бол хуулийн 6.3-т заасан түншлэлийн гэрээ.

- 13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.
- 13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.
- 14. Тендерийн маягтууд** **жишиг**
- 14.1. Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичгийн V бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтын дагуу илгээнэ.
- 15. Хувилбарт санал**
- 15.1. Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан заасан тохиолдолд оролцогч хуулийн 11.10-т заасанд нийцэх хувилбарт саналыг тендерт ирүүлж болно.
- 16. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг**
- 16.1. Оролцогч хуулийн 7.2-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 1-ийн дагуу ирүүлнэ.
- 16.2. Монгол Улсын хуулийн этгээд нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байгаа эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтыг ирүүлнэ.
- 16.3. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:
- 16.3.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;
- 16.3.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;
- 16.3.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.
- 16.4. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 14.2, 14.3-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.
- 17. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг**
- 17.1. Нийлүүлэхээр санал болгох барааны гарал үүслийн мэдээллийг V бүлгийн Маягт 2-ын холбогдох хэсэгт бөглөж ирүүлнэ.
- 17.2. Хууль тогтоомжоор барааны гарал үүслийг заавал нотлохоос бусад тохиолдолд импортын барааны гарал үүслийг нотлох баримт бичиг тендерт ирүүлэхийг шаардахгүй.

- 17.3. Оролцогчийн санал болгож буй бараа нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолтод нийцсэнийг нотлох баримтыг өгөгдлийн хүснэгтэд зааснаар тендерт ирүүлнэ.
- 17.4. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол оролцогч өөрийн санал болгож байгаа бараанд холбогдох загвар, дээжийг тендер нээх эцсийн хугацаанаас өмнө захиалагчид хүргүүлэх ба шалгалт, туршилтыг хийх ажиллагаанд оролцогчийг өгөгдлийн хүснэгтэд зааснаар оролцуулна.
- 17.5. Нотлох баримт нь нийтлэл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас хэлбэрээр байж болно. Санал болгох бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэнийг харуулах зорилгоор тэдгээрийн техникийн болон гүйцэтгэлийн бодит үзүүлэлтийг техникийн тодорхойлолттой нийцсэн болохыг хянан үзэх боломжтой баримт, хэрэв санал болгох бараа техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарласан тайлбар ирүүлсэн байна.
- 17.6. Барааг нийлүүлснээс хойш өгөгдлийн хүснэгтэд заасан хугацааны туршид тасралтгүй, горимын дагуу ашиглахад шаардагдах өгөгдлийн хүснэгтэд заасан сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалтыг тэдгээрийг авах боломжтой хаяг, үнийн мэдээллийн хамт ирүүлнэ.
- 17.7. Техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал, тоног төхөөрөмжийн загвар, хэмжих нэгж, стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар зэрэг нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.
- 17.8. Гадаадын этгээдийн хувьд гэрээний дагуу хийгдэх техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг үзүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрөө, эсхүл өөрийн Монгол Улсад байгуулсан буюу байгуулах салбар, төлөөний газар, эсхүл бусад төлөөлөгч гүйцэтгэх тухай баримт;
- 17.9. Монгол Улсын гарал үүсэлтэй бус бараа нийлүүлэхээр санал болгосон оролцогч нь техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг хэрхэн үзүүлэх тухай баримт болон мэдээлэл;
- 17.10. Хуулийн 8.4-т зааснаар давуу эрх тооцуулах барааны Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлснээр Сангийн сайдын баталсан Давуу эрх олгох аргачлал, зааврын дагуу тооцно. Барааны үнийн задаргаанд Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг заагаагүй, эсхүл гарал үүслийг нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх тооцохгүй.

- 17.11. ТШЗ-ны 1.3-т зааснаар нийлүүлэхээр санал болгох бараа Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ. Нотлох баримт бичиг ирүүлээгүй тохиолдолд тухайн барааг шаардлага хангаагүй гэж үзнэ.
- 17.12. Тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс нийлүүлэхээр санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- 18. Чадавхын болон туршлагын шаардлага**
- 18.1. Захиалагч санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг өгөгдлийн хүснэгтэд заах ба хуулийн 15 дугаар зүйлд заасныг баримтална.
- 18.2. Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана. Тухайн бараа, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нэг зөвшөөрөл, эсхүл гэрчилгээг захиалагч шаардсан бол түншлэлийн гишүүн тус бүр уг шаардлагыг хангасан байх шаардлагатай. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.
- 18.3. Түншлэл нь ТШЗ-ны 18.1-д заасан доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна. Борлуулалтын орлогын хэмжээ, ижил төстэй гэрээний үнийн дүнгийн шалгуур үзүүлэлтийг ТШЗ-ны 18.1-д заасан бол төлөөлөх эрх бүхий гишүүн уг шалгуур үзүүлэлтийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.
- 18.4. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.
- 19. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт**
- 19.1. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 19.2. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

- 19.3. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.
- 20. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт**
- 20.1. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.2, 17.2.3, 17.2.4, 17.2.5-д заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.
- 21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт**
- 21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.
- 21.2. Барааны үнийн задаргаанд багц тус бүрийн барааны нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг тусгаж ирүүлнэ.
- 21.3. Оролцогч үнийн хөнгөлөлт санал болгох бол ТШЗ-ны 14-т заасан тендер илгээх маягтад заана.
- 21.4. ТШЗ 21.3-т зааснаар үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг тендерийн үнэ гэж үзнэ.
- 21.5. Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.
- 21.6. Бараа нийлүүлэх тендерт Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргадаг Олон улсын худалдааны нөхцөл /Incoterms/-ийг хэрэглэхдээ өгөгдлийн хүснэгтэд заагаагүй бол хамгийн сүүлийн хувилбарын Delivery Duty Paid /DDP/ нөхцөлийг бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.
- 21.7. Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.
- 21.8. ТШЗ-ны 21.2-т заасан барааны үнийн задаргааны нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч тендер илгээх маягтад үнээс зөрүүтэй бол барааны үнийн задаргааны нийт нийлбэрийг тендер илгээх маягтын үнэ гэж үзнэ.

- 21.9. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.
- 22. Тендерийн валют**
- 22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.
- 23. Тендер хүчинтэй байх хугацаа**
- 23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маягтад заана.
- 23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.
- 23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь худалдан авах барааны санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.
- 24. Тендерийн баталгаа**
- 24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 24.2. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрээр ТШЗ-ны 24.1-д зааснаар ирүүлнэ.
- 24.3. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.
- Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ**
- 25. Тендер баталгаажуулах, илгээх**
- 25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.
- 25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 6-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа

26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

27. Тендерийн талаар тодруулга авах

27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх

28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасан иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн хянан үзнэ.

29. Тендерийг үнэлэх

29.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.

29.2. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.

30. Арифметик алдааг залруулах

30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.

30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.

- 31. Давуу эрх олгох**
- 31.1. Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн дотоодын бараанд хуулийн 8.4-т зааснаар давуу эрх олгож, дотоодын барааны хэсгийн үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно.
- 31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.
- 31.3. Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.
- 32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт**
- 32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.
- 33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох**
- 33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална.
- 33.2. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ.
- 33.3. ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.
- 34. Тендерийг эрэмбэлэх**
- 34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална.
- 35. Оролцогчийн чадавхыг магадлах дахин**
- 35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг дахин магадална.
- 35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 19 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 20 дугаар зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.
- 35.3. ТШЗ-ны 33.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

- 36. Шийдвэр хүргүүлэх**
- 36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.

**37. Гүйцэтгэлийн
баталгаа**

37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.

37.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.

**38. Гэрээнд гарын үсэг
зурж баталгаажуулах**

38.1. Захиалагч ТШЗ-ны 9.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.

38.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 38.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ӨХ)

| | |
|---------------------------------------|--|
| ТШЗ-ны холбогдох заалт | А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ |
| ТШЗ 1.1 | Захиалагч: Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг “Улаанбаатар төмөр зам” |
| ТШЗ 1.1 | Тендер шалгаруулалтын нэр: Зорчигчийн вагоны цахилгаан тоноглолын системийн сэлбэг худалдан авах УБТЗ/2024/НТШ/Б/37 |
| ТШЗ 1.1 | Тендерийн урилгын дугаар: МЗХННУБТЗ/20240102053 |
| ТШЗ 1.2 | Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багц № 1: НК-390 төрлийн аккумуляторын батарей Багц № 2: ВНЖ-300 төрлийн аккумуляторын батарей Багц №3: Генератор, Инвертор Багц №4: Цахилгаан тоноглолын сэлбэг Багц №5: Дамжуулгын ремень |
| ТШЗ 1.3 | Дотоодын үйлдвэрээс худалдан авах бараа байгаа бол тодорхой бич: - Байхгүй |
| ТШЗ 1.4 | Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: “Үгүй” |
| ТШЗ 2.1 | Санхүүжилтийн эх үүсвэр нь: Өөрийн хөрөнгөөр |
| ТШЗ 2.1 | Нийт төсөвт өртөг: 1,689,170,896 (нэг тэрбум зургаан зуун наян есөн сая нэг зуун далан мянга найман зуун ерэн зургаан) төгрөг Багц №1 – 521,446,700 (таван зуун хорин нэгэн сая дөрвөн зуун дөчин зургаан мянга долоон зуу) төгрөг Багц №2 – 377,137,400 (гурван зуун далан долоон сая нэг зуун гучин долоон мянга дөрвөн зуун) төгрөг Багц №3 – 79,998,100 (далан есөн сая есөн зуун ерэн найман мянга нэг зуун) төгрөг Багц №4 – 622,088,696 (зургаан зуун хорин хоёр сая наян найман мянга зургаан зуун ерэн зургаа) төгрөг Багц №5 – 88,500,000 (Наян найман сая таван зуун мянга) төгрөг |
| Б. АГУУЛГА | |

| | |
|--------------------------|--|
| ТШЗ 8.1 | <p>Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг:</p> <p>Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо, Сөүлийн гудамж-42, “УБТЗ”-ын Удирдах газар</p> <p>Утасны дугаар: +976-21-242166</p> <p>Цахим шуудангийн хаяг: nh@ubtz.mn</p> |
| ТШЗ 11.1 | Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: “Үгүй” |
| В. ТЕНДЕР БЭЛТГЭХ | |
| ТШЗ 12.1 | <p>Тендер шалгаруулалтын хэл: Монгол хэл</p> <p>Тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг Монгол улсын баталгаат орчуулгын товчоогоор орчуулуулан ирүүлнэ.</p> <p>Тендерийн материалыг Монгол хэл дээр ирүүлээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p> |
| ТШЗ 15.1 | Хувилбарт санал ирүүлэхийг: “Зөвшөөрөхгүй” |
| ТШЗ 16.2 | <p>Сүүлийн 3 жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээлэл: Шаардлагатай.</p> <ul style="list-style-type: none"> - Шүүхийн тусгай архивын лавлагаа - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт <p>Хэрэв гадаадын этгээд оролцох бол:</p> <ol style="list-style-type: none"> 1. Арбитрын эсхүл шүүхийн тодорхойлолт 2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт ирүүлэх <p>Гадаадын этгээд нь тус тодорхойлолтуудыг апостиль гэрчилгээгээр баталгаажуулан ирүүлнэ.</p> <p><i>Дээрх тодорхойлолтуудыг тендер зарлагдсан өдрөөс хойш авсан байх ба тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна.</i></p> |
| ТШЗ 16.3 | Гадаадын этгээд оролцох эрхтэй эсэх: “Эрхтэй” |
| ТШЗ 17.4 | Тендер нээх эцсийн хугацаанаас өмнө загвар, дээж ирүүлэх эсэх: “Үгүй” |
| ТШЗ 17.6 | Барааны хувьд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад эд зүйлсийн жагсаалт ирүүлэх эсэх, ирүүлэх бол хугацаа: “Үгүй” |
| ТШЗ 18.1 | Барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн шаардлага, шалгуур үзүүлэлт: “Шаардахгүй” |

| | |
|------------------------|---|
| | <p>Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний туршлагын шаардлага: “Шаардлагатай”</p> <p>2022, 2023 оны аль нэг жилд тухайн багцын батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 50% багагүй, Хэрэв 1-с дээш тооны багцад оролцвол багцуудын төсөвт өртгийн нийлбэрийн 50% хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй бараа нийлүүлсэн байх шаардлагатай.</p> <p>Ижил төстэй барааг хөдлөх бүрэлдэхүүний гэж ойлгож болно.</p> <p>Бараа нийлүүлсэн гэрээ ба гэрээ дүгнэсэн акт (протокол эсхүл дүгнэлт эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг)-ын хуулбарыг нотариатаар гэрчлүүлж ирүүлнэ. (Хэрэв "УБТЗ" ХНН -тай байгуулсан гэрээ бол нотариатаар батлуулах шаардлагагүй.) Мөн төлбөр төлсөнийг нотлох баримт, төлбөрийн ебаримт ирүүлнэ.</p> <p>Бараа нийлүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн шаардлага: “Шаардахгүй”</p> <p>Оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага: “Шаардана”</p> <p>Борлуулалтын орлогын хэмжээ: 2022, 2023 оны аль нэг жилийн борлуулалтын орлого нь тухайн багцын батлагдсан төсөвт өртгийн 50% багагүй байна. Хэрэв 1-с дээш тооны багцад оролцвол багцуудын төсөвт өртгийн нийлбэрийн 50% хувиас багагүй байна.</p> |
| <p>ТШЗ 18.2</p> | <p>Тусгай зөвшөөрөл: “Шаардана”</p> <p>Үйлдвэрлэгчээс тухайн барааг худалдан борлуулахыг зөвшөөрсөн албан ёсны зөвшөөрлийг тендер зарласнаас хойшхи хугацаанд авч хуулбарыг тендерт хавсарган ирүүлнэ.</p> |
| <p>ТШЗ 19.1</p> | <p>Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах эсэх: “Тийм”</p> <p>1. Гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн хэмжээ: Батлагдсан төсөвт өртгийн 50% багагүй байна. Хэрэв 1-с дээш тооны багцад оролцвол багцуудын төсөвт өртгийн нийлбэрийн 50% хувиас багагүй байна.</p> <p>Гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн хэмжээний нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл нийлбэрээр тус тус тодорхойлно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Байгууллагын дансны үлдэгдэл (Харилцагч банкны) - Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт ирүүлнэ. /Банкны зээлийн нөхцлийн дагуу, судлагдаж байгаа болон судалж үзээд зээл олгох боломжтой тухай гэсэн тодорхойлолтыг хүчинтэйд тооцохгүй/ - Үнэт цаас, Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд; <p>2. Банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөргүй байна. Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдээс тендер шалгаруулалт</p> |

| | |
|------------------------|---|
| | <p>зарласан өдрөөс хойш авсан, шалгах боломжтой QR код бүхий “Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг ирүүлнэ. Уг тодорхойлолтод төлөгдөж дуусаагүй зээлийн мэдээлэл “Хэвийн” бус байгаа тохиолдолд татгалзах үндэслэл болно. Оролцогч “Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг www.sainscore.mn, www.burenscore.mn хаягаар хандан авна. Харилцагч банкны тодорхойлолтыг тендерийг үнэлэхэд харгалзан үзэхгүй.</p> <p>Гадаадын этгээд оролцох бол харилцагч банкнаас хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн өргүй талаарх тодорхойлолт ирүүлнэ./</p> <p>3. Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: 2022, 2023 онуудын санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн www.e-balance.mof.gov.mn мэдээллийн системээс тендерт оролцогчдын санхүүгийн тайлангаас сүүлийн 2 жилийн борлуулалтын орлого, болон бусад шаардлагатай мэдээллийг шалгана.</p> <p>/Хэрэв гадаадын этгээд оролцох аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлнэ./</p> |
| <p>ТШЗ 20.1</p> | <p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэх эсэх: <u>“Туйм”</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын тухай товч танилцуулга ирүүлнэ. 2. Барааны үнийн задаргаа ба бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу баталгаажуулан ирүүлнэ. 3. Тендер нээсэн өдрийн байдлаар Монгол Улсын хуулийн дагуу хугацаа хэтэрсэн татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөргүй байх шаардлагатай. /Татвар болон нийгмийн даатгалын тодорхойлолтыг тендерийн баримт бичигт хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” (www.tender.gov.mn)-ээр дамжуулан шалгана./ <p>/Хэрэв тендерт гадаадын этгээд оролцох бол харьяа улсын татварын байгууллагаас ирүүлсэн татварын өргүй тухай тодорхойлолт ирүүлнэ./</p> <ol style="list-style-type: none"> 4. Нийлүүлэх барааны фото зураг, барааг дагалдаж ирэх чанарын гэрчилгээний хуулбарыг ирүүлнэ. Бараа тус бүрийн үйлдвэрлэгч, гарал үүслийг тодорхой бичиж ирүүлнэ. 5. Санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг тухайн барааны үйлдвэрлэгчээр баталгаажуулан ирүүлнэ. 6. “УБТЗ” ХНН-ийн зүгээс тендерт оролцогчийн татвар, банк, нийгмийн даатгалын хэлтэс, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон холбогдох эрх бүхий байгууллагуудаас тодруулга авахад татгалзах зүйлгүй тухай албан бичиг ирүүлнэ. 7. Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанарын шаардлага хангасан барааг захиалагчид нийлүүлэх баталгааг албан бичгээр гаргаж ирүүлнэ. 8. Баталгаат хугацаа 6 сараас багагүй байна. 9. Нийлүүлэгдсэн бараа нь захиалагчийн захиалсан эд ангид таарч тохирохгүй эсхүл чанарын шаардлага хангахгүй гэмтэлтэй ирсэн тохиолдолд ажлын 14-21 хоногт багтаан буцааж сольж өгөхийг зөвшөөрсөн албан бичиг ирүүлнэ. |

| | |
|-------------------------------|---|
| | <p>Жич: ТӨХ-д заасан материалуудын аль нэгийг тендерт хавсарган ирүүлээгүй бол тухайн тендерээс татгалзах үндэслэл болно. Мөн ТӨХ-д шаардагдаагүй үнэлгээнд нөлөөлөхүйц бус баримт бичгийг нэмэлтээр ирүүлсэн тохиолдолд үнэлгээнд харгалзахгүй болно.</p> <p>-Оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: “Шаардахгүй”</p> |
| ТШЗ 21.5. | Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “Тохируулахгүй тогтмол байна” |
| ТШЗ 21.6 | <p>Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх: “Туйм”. Incoterms 2023, DDP нөхцлөөр бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газар барааг хүргэнэ.</p> <p>Жич: Хэрэв гадаадын этгээд оролцох бол: СІР Улаанбаатар</p> |
| ТШЗ 22.1 | Тендерийн валют: Төгрөг байна. Бусад валютаар ирүүлсэн үнийг тендер зарласан өдрийн Монгол банкны хаалтын ханшаар тооцно. |
| ТШЗ 24.1 | <p>Тендерийн баталгааны дүн:</p> <p>Багц №1 – 2,607,233 (хоёр сая зургаан зуун долоон мянга хоёр зуун гучин гурван мянга) төгрөг</p> <p>Багц №2 – 1,885,687 (нэг сая найман зуун наян таван мянга зургаан зуун наян долоо) төгрөг</p> <p>Багц №3 – Шаардахгүй.</p> <p>Багц №4 – 3,110,443 (гурван сая нэг зуун арван мянга дөрвөн зуун дөчин гурав) төгрөг</p> <p>Багц №5 – Шаардахгүй</p> |
| Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ | |
| ТШЗ 25.5. | <p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <p>Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 6-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.</p> |
| ТШЗ 26.1. | <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр</p> <p>Цаг: 09 цаг 00 минут</p> |
| ТШЗ 26.2. | <p>Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.</p> <p>Огноо: 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр</p> <p>Цаг: 09 цаг 30 минут</p> |

| | |
|------------------------------------|---|
| | Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо УБТЗ-ын Удирдах газрын 3-р байр, 1 давхар, 101 тоот |
| Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ | |
| ТШЗ 29.2. | Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: “Үгүй” |
| ТШЗ 31.1. | Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг: Шаардахгүй. |
| ТШЗ 32.1 | Үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт ашиглах эсэх: Ашиглахгүй” |

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

[Захиалагч болон үнэлгээний хороо нь худалдан авах барааны техникийн тодорхойлолтыг боловсруулахад энэхүү санамжийг ашиглана.

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай барааг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендер шалгаруулалтын баримт бичгийн хэсэг болохгүй.

- Ойлгомжтой сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.*
- Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд худалдан авах барааны шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.*
- Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөвт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгаж өгнө.*
- Тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаас бусад тохиолдолд бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн технологи зэргийг хангасан байх нөхцөлийг шаардана. Өмнө хэрэгжсэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай.*
- Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэнэ.*
- Бараа материалын, техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.*

Зураг, төсөл

Шаардлагатай бол барааны эскиз, зургийг хавсаргана.

Шалгалт, туршилт

[Захиалагч оролцогчоос нийлүүлэх гэж буй бараанд үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилт хийсэн болохыг нотлох баримт, үүнтэй холбоотой мэдээлэл ирүүлэхийг шаардаж болно.


Шаардлагатай тохиолдолд захиалагч загвар, дээжийг шалгаж, туршиж болох ба шалгалт, туршилт хийсний үр дүнд тухайн загвар, дээжийн үндсэн шинж чанар алдагдсан, зориулалтын дагуу дахин ашиглах боломжгүй болсон тохиолдолд оролцогчид буцааж олгохгүй тухай техникийн тодорхойлолтод заана. Бусад тохиолдолд гэрээ байгуулсны дараа шалгарсан оролцогчийн загвар, дээжээс бусад загвар, дээжийг буцааж олгоно.

Загвар, дээжийг хэрхэн шалгах, турших тухай тодорхой заана.]


Техникийн тодорхойлолт

Нийлүүлэх бараа нь доор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.


Барааны нэр: НК-390 төрлийн батарей /Багц №1/



| Нэр төрлийн дугаар | Сэлбэгийн нэр | Техникийн тодорхойлолт болон стандарт | ОУ-ын болон үндэсний стандартын шаардлага, зургийн дугаар |
|--------------------------------|------------------------------------|--|---|
| 1. Аккумуляторын сэлбэг | | | |
| 1 | Аккумуляторын никель кадми батарей | Шингэний төрөл = шүлт Номиналь хүчдэл = 1.2 В Номиналь хүчин чадал 390 А/цаг | <p>НК-390</p>  |

Барааны нэр: ВНЖ-300 төрлийн батарей /Багц №2/

| | | | |
|---|------------------------------------|---|--|
| 3 | Аккумуляторын никель төмөр батарей | Шингэний төрөл = шүлт Номиналь хүчдэл = 1.2 В Номиналь хүчин чадал 300 А/цаг Электролитгүй жин = 10,5 кг | <p>ВНЖ-300</p>  |
|---|------------------------------------|---|--|









Барааны нэр: Генератор, Инвертор /Багц №3/









| | | | |
|---|-----------|--|--|
| 3 | Инвертор | Оролтын хүчдэл = 110В DC Гаралтын хүчдэл = 220В, 50 Гц Чадал = 6 кВт | 110Вх220Вх6кВт |
| 4 | Генератор | Үндсэн ороомгийн хүчдэл = 45 В Нэмэлт ороомог = 24 В Чадал = 10 кВт Үндсэн ороомгийн гүйдэл = 121 А Роторын эргэлтийн хурд = 940-4000 об | <p>2ГВ-003</p>  |








| | | | |
|---|-------------------------------|--|---|
| 5 | Генераторын амортизатор резин | Техникийн нөхцөл = 2500-295-001521096-93 Жин = 0.070 кгТөрөл = КВЗ-ЦНИИ 1, 18-100 | X 344400-1-05 14.45.01.164  |
| 6 | Генераторын утасны толгой | Орчны температур = -60, +60 Оврын хэмжээ 87x68x68 мм Тогтмол гүйдлийн хамгийн их хүчдэл нь 850 В-с ихгүй байна | ШРГ 55ПК 6 НШ  |









Барааны нэр: Цахилгаан тоноглолын сэлбэг /Багц №4/








| | | | |
|---|-----------------------------|--|--|
| 1 | Цахилгаан насос | Ажиллах горим = тасралтгүй Тэжээлийн хүчдэл = тогтмол гүйдэл 110В Эргэлтийн хурд = 1500 об/мин | MGC 110В  |
| 2 | Цахилгаан насос | Ажиллах горим = тасралтгүй Тэжээлийн хүчдэл = тогтмол гүйдэл 55В Эргэлтийн хурд = 1500 об/мин Жин = 13.5 кг-с ихгүй Овор = 328x162x190 | НЦ-50-55  |
| 7 | Гүүшингийн датчик | Урт =630 мм Номиналь хүчдэл = 50 В Резьба = М16х1,5 | 393-01  |
| 8 | Тэргэнцрийн ерөнхий залгуур | Утасны урт = 725 мм Жин = 0,72 кг-с ихгүй Овор = 127x90x125 мм | СК-МТР 3184001099  |
| 9 | Радио холбоос | Хүчдэл = 54 В Урт = 1,5 м Гүйдлийн хүч = 5 А | ШУ-5А  |









| | | | |
|----|--|--|--|
| 12 | 3000В халаалтын тень | Хүчдэл = 500 В Чадал = 2 кВт | ВВЭН 500/2000 ИАБЕ. 681815.016 ТУ  |
| 13 | 3000В пинч | Кабель утасны хөндлөн огтлол = 185мм ² Урт = 3,75 м | Типа -Э 018-01. 000 /Л1.0095.03.00.00/  |
| 14 | Пинч 60В | Номиналь хүчдэл = 50 В Номиналь гүйдэл = 100 А-с ихгүй | ШС-5М Пинч 60В  |
| 15 | Цахилгаан зуух | Хүчин чадал = 0.8 кВт Хүчдэл = 137 В Жин = 4,5 кг | ЭПЧ1-0,8/137  |
| 16 | Цахилгаан зуух | Хүчин чадал = 0.8 кВт Хүчдэл = 75 В | ЭПЧ1-0,8/67  |
| 17 | Хувьсгуур (Єдрийн гэрэл) 50В / 20Вт | Хүчдэл = 50 В Хүчин чадал = 20 Вт | ПРА20/50  |
| 18 | Хувьсгуур (Єдрийн гэрэл) 50В / 40Вт | Хүчдэл = 50 В Хүчин чадал = 40 Вт | ПРА40/50  |
| 19 | Вольтметр | Хэмжээ = 80x80 мм Зүүний урт = 55 мм-с багагүй Нарийвчлалын ангилал = 1.5 Жин = 0.14 гр | М42300 В100-0-100 75МВ 1.5В 00  |

| | | | |
|----|------------------------|--|---|
| 20 | Амперметр | Хэмжээ = 80x80 мм Зүүний урт = 55 мм-с багагүй Нарийвчлалын ангилал = 1.5 Жин = 0.14 гр | M42300 A100-0-100 75MB 1.5B 0  |
| 21 | Шилэн гал хамгаалагч | Их биеийн материал = Шил Номиналь хүчдэл = 600 В Номиналь чадал = 5 А | ПК-45  |
| 22 | Хуудсан гал хамгаалагч | Урт (L) = 60-135 мм Өргөн (B) = 5.5-11 мм Хүчдэл = 220-500 В | ПР-2 6А  |
| 23 | Хуудсан гал хамгаалагч | Урт (L) = 60-135 мм Өргөн (B) = 5.5-11 мм Хүчдэл = 220-500 В | ПР-2 10А  |
| 24 | Хуудсан гал хамгаалагч | Урт (L) = 60-135 мм Өргөн (B) = 5.5-11 мм Хүчдэл = 220-500 В | ПР-2 15А  |
| 25 | Хуудсан гал хамгаалагч | Урт (L) = 81-135 мм Өргөн (B) = 11-11 мм Хүчдэл = 220-500 В | ПР-2 25А  |
| 26 | Хуудсан гал хамгаалагч | Урт (L) = 81-135 мм Өргөн (B) = 11-11 мм Хүчдэл = 220-500 В | ПР-2 35А  |
| 27 | Хуудсан гал хамгаалагч | Урт (L) = 73-123 мм Өргөн (B) = 11-11 мм Хүчдэл = 220-500 В | ПР-2 60А  |



| | | | |
|----|------------------------------------|--|---|
| 28 | Хуудсан гал хамгаалагч | Урт (L) = 73-123 мм Өргөн (B) = 19-19 мм Диаметр (d) = 6.5 мм Хүчдэл = 220-500 В Нүх хоорондын зай (A) = 60-110 мм | <p>ПР-2 80А</p>  |
| 29 | Хуудсан гал хамгаалагч | Номиналь гүйдэл = 63 А Номиналь хүчдэл = 660 В Урт = 20 мм | <p>ППН-33 63А</p>  |
| 30 | Улайсах гэрэл Ж54В-25Вт | Төрөл = Ж 54-25 Хүчдэл = 54 В Чадал = 25 Вт Овор = 578x358x191 Хэмжээ L = 75, D = 50 | <p>54В-25Вт</p>  |
| 31 | Өдрийн гэрэл | Хүчин чадал = 20 Вт Өнгө = хүйтэн цагаан Гэрлийн урсгал = 1060 Lm Хамгаалалтын зэрэг = IP20 | <p>ЛБ-20</p>  |
| 32 | Өдрийн гэрэл | Хүчин чадал = 40 Вт Өнгө = хүйтэн цагаан Өнгөний температур = 2800 Lm Хэмжээ L=1213мм, D=38.5мм | <p>ЛБ-40</p>  |
| 33 | Сүүлийн дохионы гэрэл | Хүчдэл = 35 – 150 В Ажиллах температур = -50, +75 Хувийн жин = 0,5кг Хэмжээ = 170x252x80 | <p>ФКС-СИД-УМ 54В</p>  |
| 34 | Топканы гэрэл - төмөр хамгаалалтай | Хүчдэл = 54 В Чадал = 25 Вт | <p>НВВ, 01020.0175</p>  |
| 35 | Сүүлийн дохионы цагаан линз | Материал = Линз Радиус = 54.79 Өндөр = 106 мм | <p>Линза ЛР хвостового сигнального фонаря ФКС</p>  |

| | | | |
|----|--|---|--|
| 36 | Сүүлийн дохионы улаан линз | Материал = Шил Урт = 12.4 см Өргөн = 8.8 см | ГОСТ 20282-86  |
| 37 | Контактор ВГ-16 | DC - 4 Uns 110 V Ins 10 A G – 3 Uns 110 V Ins 6 A | ВГ-16  |
| 38 | Купе вагоны сахлын машины хувьсгуур 50Вх220В | Оролтын хүчдэл тогтмол = 50 В Гаралтын хүчдэл хувьсах = 220 В Чадал = 4.5 кВт | 50Вх220В  |
| 39 | Блок | Хүчдэл 50В (±3 В) | РНГ 2Б.231  |
| 40 | Хамгаалах блок | Хүчдэл 40 В, 60В, 125В | Блок зашиты БЗ 6ТР. 388. 078  |
| 41 | Хамгаалах блок | Хүчдэл 60 В, 125 В, 40 В | Блок зашиты БЗ 6ТР.388.024  |
| 42 | Цэнэглэлтийн удирдлагын блок | Хүчдэл, 60 В Гүйдэл 50+5 А | Блок управления зарядом БУЗ 6ТР.388.385  |
| 43 | Хөргөгчийн соронзон хавхлаг 110В | Хүчдэл = 110 В Эрчим хүчний хэрэглээ = 20 Вт | Danfoss № 018Z6860  |



| | | | |
|----|---------------------------------|---|--|
| 44 | Хөргөгчийн компрессор | Эзлэхүүн = 88.8 м ³ /h Зөвшөөрөгдөх хурд = 750-1750 U/min | <p>X4H2Y bitzer</p>  |
| 45 | Хөргөгчийн компрессорын сальник | 50.0 AM350 02/12 | <p>X4H2Y bitzer</p>  |
| 46 | БЗ блок заците | Хүчдэл 60 В | <p>ТИП 2Б3.003.2</p>  |
| 47 | Тиристерийн хамгаалалтын блок | Хүчдэл = 125-130 В | <p>5ТР. 066.092</p>  |
| 48 | Дундын реле МКУ48-С 54В | Орчны температур -50 °С -аас +50 ° Сэлгэн залгах хүч 500 ВА-с ихгүй 50 Вт-с ихгүй | <p>МКУ48-С 54В</p>  <p>МКУ-48</p> |
| 49 | К1 залгуур | Хүчдэл = 48-72 В | <p>К1</p>  |
| 50 | К-2 залгуур | Хүчдэл = 48-72 В | <p>К2</p>  |

| | | | |
|----|---|---|---|
| 51 | Купе вагоны сахлын машины хувьсгуур 110Вx220В | Оролтын хүчдэл тогтмол = 110 В Гаралтын хүчдэл хувьсах = 220 В | 110Вx220В  |
| 52 | Нийтийн вагоны урт гэрлийн бүрхүүл | Урт = 138 см Өргөн = 17 см | ЛВП 01-40-400  |
| 53 | Нийтийн вагоны цахилгаан удирдлагын тристор | Inp = 160 А Uас = 1400 | T15-160  |
| 54 | Купе вагоны гэрлийн ерөнхий залгуур | Хүчдэл = 54 В Чадал 16 А Байрлал = 7 туйлтай | 54В  |
| 55 | Купе вагоны гэрлийн ерөнхий залгуур | Хүчдэл = 110 В Чадал 16 А Байрлал = 7 туйлтай | 110В  |
| 56 | 380В ерөнхий залгуур | Чадал = 160 А Хүчдэл = 500 В | 110В  |
| 57 | Пакетник | Хүчдэл = 220 В Чадал = 10 А Байрлал = 5 үе туйлтай | S225-646216  |
| 58 | Нийтийн вагоны тамбарын гэрлийн бүрхүүл | Материал = шил Хэмжээ = 18x20 см | СТС-188-Б/Ц-ТМ  |

| | | | |
|----|---|--|---|
| 59 | Тасалгаат вагоны гэрэл | Эрчим хүчний хэрэглээ = 47 Вт Тэжээлийн хүчдэл = 110 В, DC | ЛВВ01-20-010  |
| 60 | Купе вагоны тамбурын гэрэл | Их бие = хөнгөн цагаан Хүчдэл = 110 В | НВВ 01-251020.0175  |
| 61 | Транзистор (металл) | PNP, 60 В, 1 А, 800 мВт, ТО-39, | BC 161-16 |
| 62 | Нийтийн вагоны хянах самбарын хавчааран гэрэл | Хүчдэл = 60 В Хүчин чадал = 3,5 Вт Жин = 5 гр | 60V50mA IV-91  |
| 63 | Хөргөгчийн термостат | Уян = 1200 mm Хүйтний уналт = 27.5 Норм дээр = 2 Норм уналт = 5 | K50-H2064 95 09-02P31  |
| 64 | Хөргөгчийн мотор 54В | Хүчдэл = тогтмол гүйдлийн 54 В Чадал = 0.25 kw Эргэлтийн хурд = 1400 об/мин | MBCV-80 54A  |
| 65 | Хөргөгчийн мотор 110В | Хүчдэл = тогтмол гүйдлийн 110 В Чадал = 1.2 кВт Эргэлтийн хурд = 1400 об/мин | MBCa-100 110A- L1-905  |
| 66 | Хөргөгчийн фильтр Liquid line filter driver | Даралт = 38 bar Шингэний температур = -45 °C, +65 °C Холболт = 6 мм | ADK-036MM-S  |
| 67 | Хөргөгчийн TRV, TEP 0.5 R134 aF M16x15 x M18x15 | TRV 642.10G16 Уян урт = 1.6 | Spez Nr 235674 EGELHOF  |

| | | | |
|----|--|---|--|
| 68 | Хувьсгуур (Өдрийн гэрэл) 1П20/110 | Хүчдэл = 110 В Хүчин чадал = 18-20 Вт | БКЕЮ.670 852 002.TY  |
| 69 | Ресторан вагоны трансформатор | Хүчдэл 380 В Чадал = 23,8 кВА Жин = 180 кг Гадна агаарын температур = 50 °С Давтамж = 50 Гц | S3TK 408 24kVA 23.8  |

Барааны нэр: Дамжуулгын ремень /Багц №5/

| | | | |
|----|------------------------|---|---|
